## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
**(2023 оны жилийн эцсийн байдлаар)**

| Шийдвэрийн дэс дугаар | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Биелэлт | Үнэлгээ | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| | | | **1. Монгол Улсын хууль** | | |
| 1 | 1. | **"Хэмжил зүйн тухай хууль" 2019** он<br>20.1.Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага харьяалах нутаг дэвсгэртээ хэмжлийн нэгдмэл байдлыг хангах чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:<br>20.1.1. Хэмжил зүйн хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | Аймаг орон нутагт хэмжил зүйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Механик, эзлэхүүн зарцуулалт, цахилгаан, даралтын хэмжлийн чиглэлээр эталон тоног төхөөрөмж, боловсон хүчнээ бэлтгэн хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын ажлыг гүйцэтгэж байна. 2023 онд:<br>Цахилгааны 5086,<br>Эзлэхүүний 225,<br>Массын 460,<br>Даралт 124,<br>Нийт 5895 ш хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулан гэрчилгээ олгосон. | 100% | |
| | 2. | 20.1.2.Ажлын эталоныг бий болгох, хадгалах, ашиглах, тэдгээрийн нэгж дамжуулалтыг хангах; | Стандарт, хэмжил зүйн газрын Эталон лаборатори, Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар-Геодезийн хэмжил зүйн лабораториудад 7 нэр төрлийн эталон төхөөрөмжийг | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | шалгалт тохируулгад хамруулан нэгж дамжуулалтыг хангасан. | | |
| | 3. | 20.1.3.Хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх; | Сум, орон нутагт ажиллах хэмжих хэрэгсэл баталгаажуулах ажлын график, төлөвлөгөө гарган 90 ААН, байгууллагуудтай гэрээ байгуулан ажилласан. 2023 оны жилийн эцсийн байдлаар 5895 ширхэг хэмжүүр, хэмжих хэрэгслийг улсын баталгаажуулалтад хамруулаад байна. Үүнээс 50 стандартын шаардлага хангаагүй хэмжих хэрэгсэлд улсын шалгагчийн албан мэдэгдэл өгч, зөрчлийг арилгуулан орон нутгийн иргэдийг буруу хэмжлийн сөрөг үр дагавраас хамгаалах, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. | 100% | |
| | 4. | 20.1.4.Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга хийх. | Хэмжлийн төрлөөр шалгалт тохируулга хийх, нэр төрлийг нэмэгдүүлэх зорилт тавин бэлтгэл ажлуудыг хангасан. Аж ахуй нэгжийн хүсэлтээр тайлант хугацаанд 112 ширхэг хэмжүүрт шалгалт тохируулга хийж гүйцэтгэсэн. | 100% | |
| 2. | 1. | **“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль” 2018 он**<br>26.1. Аймаг нийслэлийн стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллага дараах бүрэн эрхтэй.<br>26.1.1 Тохирлын үнэлгээг энэ хуульд заасны дагуу явуулах. | Баталгаажуулалтын орон тооны бус зөвлөлийн хурлыг 10 удаа зохион байгуулж, хүсэлт гаргасан ААН, иргэний хүсэлтийг шийдвэрлэж, 154 тохирлын гэрчилгээ олголоо. Стандартын шаардлага хангахгүй байгаа худалдааны газрын үйлчилгээ явуулдаг 2 ААН-ийн хүсэлтийг түр түдгэлзүүлэн стандартын шаардлага хангуулан ажиллахаар боллоо.<br><br>Нийт 154 ААН, иргэнд тохирлын гэрчилгээ олгосноос:<br>Бүтээгдэхүүн-6<br>Худалдааны газар-112<br>Хоол үйлдвэрлэлийн-26<br>Зочид буудал, дэн буудал-4<br>Жуулчны бааз-3<br>Үс засах үйлчилгээ-1<br>Хүүхдийн зуслан-1<br>Халуун ус-1 үйлчилгээнд тус тус тохирлын гэрчилгээ олгож, төсөвт 19,830,600 төгрөгийг төвлөрүүлж | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажиллалаа. | | |
| | 2. | 23.2.2 Стандарт, техникийн зохицуулалтын улсын мэдээллийн салбар санг ажиллуулах. | Байгууллагын дотоод хэрэгцээнд болон иргэд, ААН, байгууллагуудын захиалгаар 1,493,040 төгрөгийн үнэ бүхий 92 стандартыг түргэн шуурхай гарган өгч үйлчилсэн.<br>Мөн шинээр батлагдсан, хүчингүй болсон стандартын талаар мэдээллийг байгууллагын https://masm.gov.mn/dug/ цахим хуудсаар, "Дундговь стандарт хэмжил зүйн хэлтэс" албан ёсны фэйж хуудсаар дамжуулан хүргэж байна. Мөн тус байгууллагаар үйлчлүүлсэн иргэд, стандарт худалдан авсан иргэдэд www.estandard.gov.mn цахим хуудсаас стандартыг хэрхэн үнэ төлбөргүй үзэж танилцах талаар мэдээллийг хүргэн ажиллаж байна. | 100% | |
| 3 | 1. | **15.2.1 "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль"**Иргэн, аж ахуйн нэгж, улсын байцаагчийн ирүүлсэн дээжинд үндэсний болон олон улсын батлагдсан арга, аргачлалыг ашиглан шинжилгээг үнэн бодитой гүйцэтгэх | 2023 оны жилийн эцсийн байдлаар 3685 үзүүлэлтээр шинжилгээг хийж, стандартын шаардлага хангаагүй 70 үзүүлэлтээр илрүүлсэн нь нийт үзүүлэлтийн 1,9%-ийг эзэлж байна. Үүнийг задалбал: Эрүүл ахуй нян судлалын лабораторит нийт 846 сорьцод 1790 үзүүлэлтээр хийснээс стандартын шаардлага хангахгүй 40 сорьц буюу 42 үзүүлэлт, Хими, хор судлалын лабораторит 514 сорьцод 1895 үзүүлэлтээр хийснээс стандартын шаардлага хангахгүй 14 сорьц 28 үзүүлэлтээр шинжилгээ хийгдсэн байна. Зэрэг сорьцын судалгааг улирал бүрээр гарган ажиллаж байна. 2023 онд 1360 сорьцод 3685 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс 54 сорьц нь буюу 70 үзүүлэлтийн 1,9% нь стандартын шаардлага хангаагүй байна. Стандартын шаардлага хангаагүй зэрэг гарсан үзүүлэлтийн 0,9% нь хоолны илчлэг чанар стандартад заагдсан хэмжээндээ хүрээгүй, 3,5% нь ундны усны сорьцноос,3,2% нь арчдаст шинжилгээ, бохир усны шинжилгээний үзүүлэлтийн 50 нь зэрэг ,4.5% нь ажлын байрны агаараас, 6%-нь хөрсний шинжилгээ эзэлж байна. | 100% | |
| | 2. | **15.2.5 "Хүнсний бүтээгдэхүүний** | 2023 оны I, II ээлжийн ур чадварын түвшинг тогтоох | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **аюулгүй байдлыг хангах тухай хууль** "Хүнсний сүлжээ лабораториудын ур чадварын хөтөлбөрт хамрагдах | хөтөлбөрт лабораторийн ажилтнууд нь багаараа 2 удаа оролцон, нийт 6 сорьцод 6 үзүүлэлтээр /Ундны усанд хатуулаг, Бактериар халдварлуулсан шингэн орчинд enterococcus сахароз, псевдомонус тодорхойлох шинжилгээг хийж хангалттай үнэлгээ авч ажиллалаа. Шинжээч Б.Бямбажав Ус цаг уур орчны шинжилгээний газрын итгэмжлэгдсэн лабораторитой лаборатори хоорондын харьцуулалтын шинжилгээг 1 сорьцод 4 үзүүлэлтээр хийж дүгнэхэд 2 шинжээч хоорондын таарц тохирч байсан тул үр дүнгийн үнэн бодит байдлын чанар хангалт сайн гэж дүгнэлээ. | | |
| | 3. | **15.2.6 "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль"** Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагыг хангах | Лабораторийн үйл ажиллагааг MNS/ISO IEC 17025:2018 стандартад нийцүүлэн итгэмжлэлийн хүчин төгөлдөр байдлыг хангах ажлын хүрээнд итгэмжлэлийн хүрээг өргөтгөн ажилласан. Дотоод хяналтыг 2 удаа зохион байгуулан байгууллагын удирдлагад танилцуулсан. УДШ-ний хурлаар 2024 онд лабораторид зайлшгүй шаардлагатай 2ш багаж /татах шүүгээ, анарестат/ багаж авахаар төлөвлөсөн. СХЗГ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг явцын хяналт-шинжилгээ хийж. ХАБҮЛЛ-ын хими хор судлалын ахлах шинжээч П.Билгүүн Сорилтын лабораторит тавигдах MNS ISO IEC 17025:2018 стандартын дагуу хяналт шалгалт хийж арга зүйн өгч ажиллалаа. 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Стандарт Хэмжил зүйн газрын даргын А/168 дугаар тушаалын дагуу итгэмжлэлийн хугацаагаа 4 жилээр сунган ажиллаж байна. Сорилтын лаборатори нь MNS/ISO IEC 17025:2018 стандартад нийцүүлэн 2020 онд 79 төрлийн бүтээгдэхүүнд 393 үзүүлэлтээр шинжилгээ хийх эрх авч үйл ажиллагаа явуулж байна.<br><br>2024 оны 01 сарын 13-нд итгэмжлэлийн хугацаа дуусна. Итгэмжлэлийн үнэлгээний төвийн магадлан итгэмжлэлд 2022 онд хамрагдсан. 2024 онд итгэмжлэлийн хугацаагаа сунгуулан ажиллана. Химийн бодис ашиглах тусгай | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | зөвшөөрлийн гэрчилгээг 3 жилээр 413 нэр төрлийн бодис ашиглахаар 2021 оны 12 сарын 13-ны өдөр авсан буюу, 2024 оны 03 сарын 31 -ны өдөр дуусна. | | |
| | 4. | **15.4 "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль".** Шинжилгээний үр дүнгийн мэдээллийн санг бүрдүүлэх | Дээж хүлээн авагч шинжээч нь нийт 3685 үзүүлэлтийг цахимд бүртгэлжүүлэн шинжээч нарт дээж хуваарилан хариу олгох хүртэл арга хэмжээг зохион байгуулан шинжилгээний мэдээ мэдээллийн LIMS системийн тасралтгүй үйл ажиллагааг ханган улирал бүр тоон мэдээллийг гаргаж, ажлын хуудсыг хянуулан хавсаргаж, мэдээ судалгааг гарган журмын хэрэгжилтийг ханган ажилласан. Нийт зерэг гарсан сорьцыг давтан шинжилгээнд хамруулсан байдлыг авч үзвэл: 70 үзүүлэлтээс 49 сорьцыг давтан шинжилгээнд хамруулан ажилласан нь нийт зерэг гарсан шинжилгээний 0.3%-ийг эзэлж байна. Бусад 21 үзүүлэлт нь давтан шинжилгээнд хамрагдаагүй байна. 2023 онд **Д.Сүнжидмаа** 10 сорьц 19 үзүүлэлтийг: / 6 хоолны илчлэг хэмжээндээ хүрээгүй, 5 бохир ус, гүний ус /хатуулаг, кальци, магни,хлор, сульфат зэрэг 8 үзүүлэлтийг/, **Г.Мөнхсарнай** 23 сорьц 25 үзүүлэлт / ажлын байрны хөгц 4, ажлын байрны нянгийн тоо их 1, арчдасны нянгийн тоо их 12 , арчдасанд энтербактер 1, арчдасанд E.Coli 1, арчдасанд хөгц 1, шүүсэн усанд нянгийн тоо их 1, гүний усанд нянгийн тоо өндөр 2 , хөрсөнд колититр 1, припренгенс 1/, **Э.Анхчимэг** 17 сорьц 17 үзүүлэлтийг / 12 арчдасны нянгийн тоо их, 5 усны нянгийн тоо өндөр/, **Б.Бямбажав** 4 гүний усанд 9 үзүүлэлтийг / кальци, магни, төмөр, хатуулаг зэрэг 9 үзүүлэлтийг/ өөрчлөлттэй гарсныг тус тус илрүүлэн ажилласан байна. | 100% | |
| | 5. | **15.2.8 "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль "** Лабораторийн шинжилгээний аргын үндэсний стандартуудад үзлэг хийж, шинэчлэн батлагдсан стандартыг | Хими хор судлал, нян судлалын лабораторид ашиглагдаж байгаа нийт 82 стандартад үзлэг хийж, 22 стандартыг шинээр захиалан авсан. Шинэчлэн батлагдах 2 төрлийн стандартад ХАБҮЛЛ-д санал хүргүүлэн ажилласан. Нян судлалын лабораторийн стандартуудад үзлэг хийн, | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | захиалан авах, стандартад санал өгөх | захиалж авахаар 25 төрлийн аргын стандарт, 2 төрлийн техникийн шаардлагын судалгааг гарган ажилласан. Хими хор судлалын лаборатори нь 8 төрлийн техникийн шаардлагын стандартын судалгааг гарган захиалж авсан. | | |
| | 6. | **5.0“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль**<br>Химийн хорт болон аюултай бодистой холбогдох үйл ажиллагааны зөвшөөрөл | Химийн хорт болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрлийг 413 нэр төрлийн бодисонд 3 жилийн хугацаагаар авч 2024 он хүртэл ашиглахаар үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэн ажиллаж байна. | 100% | |
| | 7. | **Химийн хорт болон аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг зохицуулах**<br>6.1.7. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагааны мэдээ, тайланг нэгтгэж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх; | Шинжээч Б.Бямбажав нь химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагааны тухай хуулийг лабораторийн 5 албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Химийн урвалж бодис ашиглалт зарцуулалтын тайланг химийн шинжээч Д.Сүнжидмаа нь улирал бүр гаргаж жил бүрийн 12 сарын 15-ны өдрийн дотор химийн урвалж бодис зарцуулалтын тайланг Сайнцагаан сумын ЗДТГ-т хүргүүлэн ажиллахаар бэлтгэл ажил хангаад байна. | 50% | |
| | 8. | 10.2.,10.3 13.0 Химийн хорт болон аюултай бодисыг түүний онцлог шинж анарыг нь харгалзан зориулалтын тусгай агуулахад энэхуулийн 6.1.2-т заасны дагуу батлагдсан журмыг баримтлан хадгална | Химийн бодисын агуулахад улсын байцаагчийн 13-04-010/88 тоот дүгнэлт гаргуулан зориулалтын лабораторид батлагдсан журмын дагуу хадгалж бүртгэлжүүлэн байнгын хяналтыг тавьж ажиллаж байна. Хадгалж байгаа химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодол нь тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарыг бичсэн шошготой бүртгэл зарцуулалтыг тогтмол хийн ажиллаж байна. Галын аюулгүй байдлыг хангах зорилгоор ОБГ-аас сургалт авч үзүүлэх сургалт зохион байгуулсан. Химийн бодис хадгалах өрөөнд тохижуулалт хийж 2 сейф нэмж тусгаарлах бодисуудыг тусад нь ангилан жагсаалтыг гарган бүртгэлжүүлэн ажиллаж байна. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **4** | | **“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хууль** | | | |
| | **1** | 8.2.1. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилгыг байгууллагын https://masm.gov.mn/dug/ цахим хуудсанд байршуулсан. Мөн байгууллагын мэдээллийн самбарт ил тод байршуулан ажиллаж байна. | 100% | |
| | **2** | 8.2.2. Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Тус байгууллагын хэмжил зүй, тохирлын үнэлгээ, салбар сан, сорьцын хяналт, сорилтын лабораторийн чиглэлээр хэрэгжүүлэх чиг үүрэг, байгууллагын бүтэц, зохион байгуулалтын схем, байгууллагын харилцах утасны дугаар, мэйл хаяг зэрэг мэдээллийг https://masm.gov.mn/dug/ цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулсан. | 100% | |
| | **3** | 8.2.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Байгууллагын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, байгууллагын үйл ажиллагааны 2023 оны эхний хагас жилийн тайлан, санхүүгийн аудитын тайлан гэх зэрэг тайлан мэдээллүүдийг https://masm.gov.mn/dug/ цахим хуудасны ил тод байдал цэсэнд байршуулсан. | 100% | |
| | **4** | 8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар гарган, https://masm.gov.mn/dug/ цахимд хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан. | 100% | |
| | **5** | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | Албан хаагчдын өрөөний үүдэнд тухайн албан хаагчийн овог, нэр, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг, хэрэгжүүлэх чиг үүрэг, иргэдийг хүлээн авч, төрийн үйлчилгээ үзүүлэх цагийн хуваарь зэргийг байршуулсан. Мөн эдгээр мэдээллийг байгууллагын цахим хуудасны танилцуулга цэсэнд байршуулсан. | 100% | |
| | **6** | 8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг хугацаанд нь гарган холбогдох газарт хүргүүлэн ажиллаж | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | байна. Мөн энэхүү тайланг PDF хэлбэрээр цахимд байршуулан ажиллаж байна. | | |
| | 7 | 8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. | Тус хэлтсээс холбогдох газруудтай хамтран зохион байгуулсан “Стандарт ба хөгжил” хэлэлцүүлэг, “Эрсдэл ба стандарт” форум, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Иргэнд ээлтэй стандарт” нээлттэй мэдээллийн өдөрлөг, Аймгийн “Хоол үйлдвэрлэлийн салбарын ажилтнуудын зөвлөгөөн”, Аймгийн “Худалдааны салбарын ажилтнуудын зөвлөгөөн” зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдийн хөтөлбөр, мэдээллийг өөрийн байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд хүргэн ажиллаж байна. | 100% | |
| | 8 | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Тус хэлтсийн нярвын ажлын сул орон тооны зарыг https://masm.gov.mn/dug/ цахимд хуудасны сул орон тооны зар хэсэгт байршуулсан. Мөн байгууллагын фэйсбүүк хуудсанд байршуулан, сул орон тооны зарыг иргэдэд нээлттэй мэдээлсэн. | 100% | |
| | 9 | 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | Улсын их хурлын 13 дугаар тогтоолоор батлагдсан “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ УДИРДАХ АЛБАН ТУШААЛД ТОМИЛОГДОХ АЖИЛТНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ”-ыг https://masm.gov.mn/dug/ цахим хуудсанд байршуулсан. | 100% | |
| | 10 | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 98 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар баталсан Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлалыг https://masm.gov.mn/dug/ цахим хуудасны хүний нөөц цэсэнд байршуулсан. | 100% | |
| | 11 | 8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төслийг шилэн дансанд байршуулсан. https://shilendans.gov.mn/organization/21914 | 100% | |
| | 12 | 8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн | Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг шилэн дансанд байршуулсан. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тайлан; | https://shilendans.gov.mn/organization/21914 | | |
| | 13 | 8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг шилэн дансанд байршуулсан. https://shilendans.gov.mn/organization/21914 | 100% | |
| | 14 | 8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээний талаар мэдээллийг шилэн дансанд байршуулсан. https://shilendans.gov.mn/organization/21914 | 100% | |
| | 15 | 8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг шилэн дансанд байршуулсан. https://shilendans.gov.mn/organization/21914 | 100% | |
| | 16 | 8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг шилэн дансанд байршуулсан. https://shilendans.gov.mn/organization/21914 | 100% | |
| | 17 | 8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт шилэн дансанд байршуулсан. https://shilendans.gov.mn/organization/21914 | 100% | |
| | 18 | 8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг шидэн дансанд байршуулсан. https://shilendans.gov.mn/organization/21914 | 100% | |
| | 19 | 8.4.9. Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | 2023 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансанд 150 мэдээ оруулахаас 141 мэдээ оруулж, 9 мэдээ хугацаа хоцроож байршуулсан байна. | 94% | |
| | 20 | 8.4.10. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг шилэн дансанд байршуулсан. https://shilendans.gov.mn/organization/21914 | | |
| | 21 | 8.5.1. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, тохирлын үнэлгээний баталгаажуулалт, стандартын үнэ тарифын мэдээлэл, тохирлын гэрчилгээ авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг байгууллагын мэдээллийн самбар болон https://masm.gov.mn/dug/ цахим хуудасны үйлчилгээ цэсэнд байршуулсан. | 100% | |
| **Хэсгийн дундаж: 98,4** | | | | | |
| **2.Улсын Их Хурлын тогтоол** | | | | | |
| 5. | 1 | **2019_21. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай**<br>1.“Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай. | Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмын дагуу тус байгууллагын төрийн захиргааны 5 албан хаагч зэрэг дэвийн 18-32%-ийн нэмэгдэл авч байна. | 100% | |
| | 2 | МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ<br>2022-11-11<br>Дугаар 2022 №72<br>1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан | Баримт бичиг хүлээн авах, илгээх үйл ажиллагааны 90%-нь цахимаар илгээж, бичгийн цаасны хэмнэлт хийж байна. Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын мэргэжилтэн, бүтээгдэхүүн баталгаажуулалтын мэргэжилтэн, хэмжил зүйн хяналтын улсын байцаагч нар хөдөө сумдад ажиллахдаа нэг унаагаар явж, үйл ажиллагаагаа уялдуулан, бензин, шатах, тослох материалын зардлыг хэмнэж байна.<br>Уул уурхайн компаниудад авто пүүний баталгаажуулалтын ажил гүйцэтгэхэд бензиний зардлыг тэдгээр компаниудаас гаргуулж ажиллаж байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тохиолдолд боловсруулах; | | | |
| Хэсгийн дундаж: 100 | | | | | |
| 3. Улсын их хурлын байнгын хорооны тогтоол | | | | | |
| 6. | 1 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | “Үндэсний хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх” ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн хэрэгжилтийг хангах, 2025 оноос төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлын хүрээнд Монгол хэл, уран зохиолын багш О.Цэцэгээтэй гэрээ байгуулан, тус байгууллагын 9 албан хаагч үндэсний бичгийн модуль-II сургалтад хамрагдаж, гэрчилгээ гардан авсан.<br><br>Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвеллийн ажлын албанаас “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ийн хэрэгжилтийн явцыг танилцуулах, үндсэний бичгээр цахим бичвэр боловсруулах, хэвлэмэл хуудас ашиглан турших” сургалтад 3 албан хаагч хамрагдсан.<br><br>Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудын монгол бичгээр цахимд бичих чадварыг дээшлүүлэх, албан бичиг хэргийг хос бичгээр алдаагүй зөв боловсруулах, хэвлэх, хянах чадварт сургах сургалтад архив, бичиг хэргийн ажилтан хамрагдсан.<br><br>Байгууллагын гадна хаяг, албан хаагчдын өрөөний хаяг зэргийг кирилл, монгол бичиг хос бичгээр хийлгэн байршуулсан. Мөн албан хэргээ хос бичгээр хөтлөх явуулах бэлтгэл ажлын хүрээнд албан хаагчдын компьютерт монгол бичгийн үсгийн фонт суулгаж, албан | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хаагчид үндэсний бичгээр баримт бичиг боловсруулах дадлага хийж гүйцэтгэж байна. | | |
| | 2 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30<br>Дугаар 2019_104<br>1.5.Улсын хэмжээнд ажиллаж буй хүнсний аюулгүй байдлын лабораторуудыг олон улсын магадлан итгэмжлэлд оруулах, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний бүтэц, найрлагыг нарийвчлан тогтоох, чанар аюулгүй байдлыг баталгаажуулах, судалгаа шинжилгээ хийх чиглэлээр чадавхжуулах, олон улсад ашиглаж буй стандартуудтай жишсэн үндэсний шинжилгээний арга, аргачлалын стандартыг шинэчлэн боловсруулах, харилцан мэдээлэл солилцох, ялангуяа хүний эрүүл мэндэд хортой бодис илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч ажиллах чиглэлээр нэгдсэн бодлого зохицуулалт хийх. | Лабораторийн үйл ажиллагааг MNS/ISO IEC 17025:2018 стандартад нийцүүлэн, итгэмжлэлийн хүчин төгөлдөр байдлыг хангах ажлын хүрээнд итгэмжлэлийн хүрээг өргөтгөн ажилласан. 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Стандарт Хэмжил зүйн газрын даргын А/168 дугаар тушаалын дагуу итгэмжлэлийн хугацаагаа 4 жилээр сунган ажиллаж байна. Сорилтын лаборатори нь MNS/ISO IEC 17025:2018 стандартад нийцүүлэн 2020 онд 79 төрлийн бүтээгдэхүүнд 393 үзүүлэлтээр шинжилгээ хийх эрх авч үйл ажиллагаа явуулж байна. 2024 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр итгэмжлэлийн хугацаа дуусаж, итгэмжлэлд хамрагдана. Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрлийн гэрчилгээг 3 жилээр 413 нэр төрлийн бодис ашиглахаар 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдөр авсан. MNS/ISO IEC 17025:2018 стандартад нийцүүлэн лабораторийн бодлого, үйл ажиллагааны заавар, баримтлах 24 журмыг СХЗГ-ын даргын тушаалаар шинэчлэн боловсруулсан. Лабораторийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах, нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын удирдлагад болон СХЗГ-т 2 төрлийн тоног төхөөрөмж авах судалгааг хүргүүлэн ажилласан. **Хийж байгаа аюулгүй үзүүлэлтүүд:** Эрүүл мэндийн сайдын А/384 тушаалаар батлагдсан аюулгүй үзүүлэлтийн жагсаалтыг судлан хими, хор судлалын лаборатори 11 үзүүлэлтээр, нян судлалын лаборатори 26 үзүүлэлтээр нийт 37 үзүүлэлтээр аюулгүй үзүүлэлтийг нэмэгдүүлэн итгэмжлэлийн хүчин төгөлдөр байдлыг | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ханган ажиллаж байна. Мөн химийн хор судлалын лаборатори нь хүнсний ногоо, жимс, гурилан бүтээгдэхүүнд 2 төрлийн пестицид тодорхойлж байсан бол энэ жил 1 төрлийн оношлуурыг захиалан авч шинжилгээний арга, аргачлалыг нэвтрүүлэн ажиллаж байна. Хүн амд сөргөөр нөлөөлж буй химийн хорт бодисыг тодорхойлох шаардлага гарвал ХАБҮЛЛ-д хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Аймаг орон нутгийн хэмжээнд итгэмжлэлийн хүрээнд заагдсан үзүүлэлтүүдийг тодорхойлон, хордлого гарсан, гомдлоор ирсэн дээжийг Монгол Улсын шадар сайдын баталсан 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/68 дугаар тушаалыг баримтлан шинжлэх ажлыг хийж байна. | | |
| | **3** | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/<br>2021-10-04<br>Дугаар 2021_58<br>2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | "Дундговио ногооруулъя" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Стандарт хэмжил зүйн салбарын 100 жилийн ой, "Дэлхийн хэмжил зүйн өдөр"-ийг тохиолдуулан тус хэлтсийн албан хаагчид "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-д нэгдэж, паркын зам дагуух өмнөх тарьсан модоо услаж, тордон сэргээж, шинээр нэмж 200 ш хайлаас модыг соёл амралтын хүрээлэнгийн хашаанд тарьж суулгалаа. | 100% | |
| | **4** | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай<br>2022-07-11<br>Дугаар 2022_159<br>2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн | Тус байгууллагын дарга, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын мэргэжилтэн, бүтээгдэхүүн баталгаажуулалтын мэргэжилтнүүдийн өрөөнд Чингис хааны хөргийг залж, байрлуулсан. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | залсугай.<br>4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв еэз сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | | | |
| **Хэсгийн дундаж: 100** | | | | | |
| **4. Засгийн газрын тогтоол** | | | | | |
| **7** | **2** | 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл<br>2022-02-16<br>Дугаар 2022_11<br>XIX.6.2. "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав. | Стандарт, хэмжил зүйн салбарын нэгдсэн системийг хөгжүүлэх ажлын хүрээнд СХЗГ-ын Хэмжил зүйн үйл ажиллагаа, үйлчилгээг цахимжуулах ажлын хэсэг хуралдаж иргэд, аж ахуйн нэгжид үзүүлдэг дараах үйлчилгээг цахимжуулахаар ажлын даалгавар боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж буй талаар мэдээлэл ирүүлсэн.<br>Үүнд:<br>•Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга<br>• Хэмжил зүйн үйл ажиллагааны чадавхыг үнэлэх<br>• Хэмжих хэрэгслийн загварын туршилт<br>•Хэмжих хэрэгсэл шалгалт баталгаажуулалт зэрэг үйлчилгээ болно.<br>Өнөөдрийн байдлаар стандартын лавлагаа, мэдээллийн үйлчилгээг www.estandard.gov.mn сайтаар дамжуулан үзүүлж байна. 2023 онд тус аймгийн 38 иргэн энэхүү цахим хуудастай танилцсан байна.<br>Цаашид Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газар, Сорьцын хяналтын газрын үйл ажиллагаа, үйлчилгээ, мэдээллийн санг цахимжуулах ажлын даалгаврыг боловсруулан төр хувийн хэвшлийн түншлэлээр стандарт, хэмжил зүйн салбарын нэгдсэн | 70% | |